

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

Г “Баруун-Урт-Ус” ХК-ийн үнэт цаасыг Г
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Баруун-Урт-Ус” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 57912 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Компанийн зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж байгаатай холбогдуулан хуулиар хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Баруун-Урт-Ус” ХК /З.Нарангэрэл/-д үүрэг болгосугай.

3. Энэ тухай Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдэгдэж тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Х.БУМ-ЭРДЭНЭ